



ГАРЧИГ

✦ 1–4	Бодлогын нийтлэл
✦ 5–7	Зохицуулалтын мэдээ
✦ 8	Байр суурь
✦ 9	Ногоон санхүүгийн байдлын тайлан
✦ 10–13	P2P зээлийн үйлчилгээний тухай
✦ 14–19	Даатгалын компанийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх арга замууд, олон улсын туршлага
✦ 20–23	Санхүүгийн боловсрол
✦ 24–25	Компанийн засаглал
✦ 26	Олон улсын зах зээлийн мэдээ
✦ 27	Статистикийн тооцооллын суурь ойлголтууд хичээл №10
✦ 28	Олон улсын хөрөнгийн зах индекс

МЭНДЧИЛГЭЭ



Монгол Улсын санхүүгийн зах зээлийн мэргэжлийн оролцогчид, үе үеийн ажилтан, албан хаагчид, салбарын холбоод, харилцагч, үйлчлүүлэгч, иргэд Та бүхэндээ айлчлан ирж буй шинэ оны мэндийг дэвшүүлье.

Санхүүгийн зохицуулах хорооны хувьд улиран одож буй 2022 ондоо шинэ технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг бодлогоор дэмжиж, байгаль орчинд ээлтэй ногоон бүтээгдэхүүн бий болгох, зах зээлд шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг сэндрбоксын зохицуулалтаар дэмжих, санхүүгийн зах зээлийн эрх зүйн орчныг шинэчлэх, банкны реформыг хийж банкнуудыг нээлттэй компани болгох зэргээр өмнө тулгарч буй сорилтуудаа бодит боломж болгоход анхаарч ажиллалаа.

Үүний үр дүнд урьдчилсан тооцооллоор зохицуулалтын байгууллагуудын зах зээлийн үнэлгээ, хөрөнгийн дүн ДНБ-ий 25.7 хувьд хүрч өсөхөөр байна. Банкны реформын хүрээнд эрх зүйн зохицуулалтын орчныг бүрдүүлж, системийн нөлөө бүхий 3 банкны нийтэд санал болгох үнэт цаасыг бүртгэж, хөрөнгийн зах зээлд 2 банкны хувьцаа арилжиж эхэлснээр хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 1.5 их наяд төгрөгөөр өслөө.

Түүнчлэн Биржийн бус зах зээлд бүтээгдэхүүн гарах зохицуулалтыг бий болгосноор 1.2 их наяд төгрөгийн бүтээгдэхүүнийг бүртгэж,

нийт 787.0 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлээд байна. Тайлант оны онцлох ажлын нэг бол виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн эрх зүйн орчныг бүрдүүлж, 11 хуулийн этгээдийг бүртгэж, хяналтын механизмыг бүрдүүлэх цогц арга хэмжээг авч ажиллаж байгаа бөгөөд ФАТФ-ын Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн гишүүн орнуудад “сайн туршлага” хэмээн үнэлэгдэж өндөр хөгжилтэй улс орнууд туршлага судлах хүсэлтээ манайд ирүүлж байна.

Олон улсын зохицуулагч байгууллагуудын зүгээс уур амьсгалын өөрчлөлтөд хувь нэмрээ оруулж, байгаль орчинд ээлтэй ногоон бүтээгдэхүүнийг дэмжих зорилт тавин ажиллаж байгаа билээ. Энэ зорилтын хүрээнд бодлого, зохицуулалтын шийдвэрүүдийг гаргаж, “Байгаль орчин, нийгэм, засаглалын тайлагналын стандарт”-ыг батламжилсан ба даатгалын зах зээлд 3 төрлийн ногоон даатгалын бүтээгдэхүүн, хөрөнгийн зах зээлд ногоон бонд гарч, ББСБ-уудын нийт зээлийн 2 хувь нь ногоон төслийг санхүүжүүлэхэд зориулагдан дэлхий нийттэй хөл нийлүүлэн алхах эхлэлээ тавиад байна.

Санхүүгийн зохицуулах хорооны хувьд 2023 он маань олон тулгуурт, хүртээмжтэй, цахим технологид суурилсан санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх, регтек, суптекийг нэвтрүүлэх, байгаль орчинд ээлтэй ногоон бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх талаар бодлого, зохицуулалтаа чиглүүлж, зах зээлд гарч буй өсөлт, хөгжлийг тогтвортой хадгалж, амжилтаа ахиулсан жил болно гэдэгт итгэлтэй байна.

Санхүүгийн зах зээлийн хөгжлийн төлөө сэтгэл, зүтгэлээ зориулан ажилладаг нийт ажилтан, албан хаагч, хамтран ажилладаг мэргэжлийн холбоод, зохицуулалтын байгууллагууд, хөрөнгө оруулагч, даатгуулагч, харилцагч үйлчлүүлэгч, иргэд Та бүхэнд ирж буй шинэ ондоо ажил үйлс тань өөдрөг, эрүүл, энх байхын өлзийтэй ерөөлийг өргөн барья.





ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

АУДИТ

Санхүүгийн хяналтын практик буюу бүртгэлийн утгаар аудитын үүрэг нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, хөрөнгө мөнгийг зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг нягтлах явдал болно. Энэ явцуу утгаар аудит нь санхүүгийн зохистой менежментийг хангах, хууран мэхлэлт, авлигыг таслан зогсоох оролдлого юм.



AUDIT

The practice of fiscal scrutiny – the role of audit in its accounting meaning – is concerned to verify the accuracy of financial statements and to check whether money has been spent for the purposes declared. In this narrow sense, audit is an effort to ensure sound financial management, and to stop fraud and corruption.

*Эх сурвалж:
Засаглалын үзэл баримтлал, нэр
томъёоны тайлбар толь бичиг*



БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭДИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭД ГЭЖ ХЭН:

Олон улсад өргөнөөр үйлдэгддэг мөнгө угаах гэмт хэрэг гэдэг нь гэмт хэрэг үйлдэж олсон хууль бус хөрөнгийг зах зээлд эргэлтэд оруулах замаар эх үүсвэрийг нуун дарагдуулж, хууль ёсны орлого мэт харагдуулах үйл ажиллагаа юм. Иргэд энэ төрлийн гэмт хэргийг хэрхэн үйлдэгддэг талаар мэдлэг мэдээлэл дутмаг байдгаас уг гэмт хэрэгт өртөх эрсдэлтэй байдаг. Мөнгө угаахаар зорьж буй этгээд нь “бохир мөнгө”-ийг хамгийн түрүүнд санхүүгийн болон санхүүгийн бус салбарын байгууллага, үйлчилгээ үзүүлэгч этгээдээр дамжуулан зах зээлийн эргэлтэд оруулж, эх үүсвэрийг далдлахыг зорьдог тул мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид нь харилцагчийг таньж мэдэх, мэдээлэх үүргээ хэрэгжүүлэх нь хамгийн чухал юм. Иймд эрсдэлээс урьдчилан сэргийлэх, мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийг хэрэгжүүлж улс орны эдийн засгийг хамгаалах үүднээс тодорхой этгээдүүдийг “Мэдээлэх үүрэгтэй этгээд” гэж үзэн хуулийн дагуу тодорхой эрх, үүргийг олгосон байдаг.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1–д дараах этгээдүүдийг мэдээлэх үүрэгтэй этгээд гэж заасан байна.

Үүнд:

1. Банк;
2. Банк бус санхүүгийн байгууллага;
3. Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч;
4. Хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын менежментийн компани;
5. Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага;
6. Хадгаламж, зээлийн хоршоо;
7. Үл хөдлөх хөрөнгө худалдан авах, эсхүл худалдах аливаа ажиллагаа явуулсан бол үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага;
8. 20 сая төгрөг (түүнтэй тэнцэх гадаад валют) болон түүнээс дээш үнийн дүн бүхий бэлэн мөнгөний гүйлгээнд оролцсон бол үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч;
9. Нотариатч, хуульч, эсхүл нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн харилцагчтай холбоотой дараах ажиллагааг бэлтгэсэн, хийсэн, эсхүл оролцсон бол:
 - x. Үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах;
 - xi. Харилцагчийн хөрөнгийг удирдах;

- xii. Банкны, хадгаламжийн, үнэт цаасны дансыг удирдах;
- xiii. Компанийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдахад зориулан хөрөнгө татах, бүрдүүлэхийг зохион байгуулах;
- xiv. Хуулийн этгээдийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдах, эсхүл хэлцлийн үндсэн дээр аливаа тодорхой үйл ажиллагаа явуулах, удирдах, эсхүл аж ахуйн нэгжийг худалдах, худалдан авах.

10. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч.

МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭДИЙН ЧИГ ҮҮРЭГ

Мэдээлэх үүрэгтэй этгээд (цаашид “МҮЭ” гэх) нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх (МУТС) гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

- Гүйлгээнд хяналт тавих;
- 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний, гадаад төлбөр тооцоо болон виртуал хөрөнгийн гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн алба (цаашид “СМА” гэх)–нд мэдээлэх;
- Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ тухай 24 цагийн дотор сэжигтэй гүйлгээний тухай батлагдсан маягт, журмын дагуу СМА–нд мэдээлэх;
- Эцсийн өмчлөгч тогтоох;
- Харилцагчийг таньж мэдэх;
- Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөл болон эрх бүхий байгууллагаас гаргасан хориг арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Харилцагчийн талаарх баримт, материалыг хадгалах;
- Мэдээллийн нууцлалыг хадгалах;
- Гүйлгээний хяналт, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны дагуу тусгай хяналт тавих.

СМА нь нийт МҮЭ–ийн мэдээлсэн гүйлгээнд хяналт тавьж, дүн шинжилгээ хийх, МУТС гэмт хэрэгт холбоотой гэж сэжиглэсэн гүйлгээг хууль сахиулах байгууллагад шилжүүлэх чиг үүргийг хүлээдэг. МҮЭ–ийн гүйлгээг мэдээлэх чиг үүргийн хүрээнд “Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэл ирүүлэх журам”–ыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны А–171 дугаар тушаалаар шинэчлэн баталсан. Тус журмын дагуу СМА нь 2022 оны 7 дугаар сарын 01–ний өдрөөс ГоАМЛ цахим программыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан гүйлгээг зөвхөн ГоАМЛ порталаар хүлээн авахаар болсон юм.

Үүний дагуу ГоАМЛ программд бүртгүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангуулахтай холбоотой 2022 оны 11 дүгээр сарын 22–ны өдрийн 9/4491 тоот анхааруулгыг Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтад хамаарах МҮЭ–үүдэд хүргүүлээд байна.

МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭДЭД ТАВИХ ХЯНАЛТ

Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалттай нийт салбарт 2022 оны 12 дугаар сарын 01–ний өдрийн байдлаар 1,700 гаруй мэдээлэх үүрэгтэй этгээд үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр этгээдийн МУТС чиглэлээрх үйл ажиллагаа, МҮЭ–ийн хуулиар хүлээсэн үүргийг биелүүлж байгаа байдалд Санхүүгийн зохицуулах хорооноос зайны хяналтыг тогтмол хэрэгжүүлж ажилладаг.

Зайны хяналтын хүрээнд эдгээр МҮЭ тус бүрийн МУТС эрсдэлийг Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 339 дүгээр тогтоолоор баталсан “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”–ын дагуу хагас жил тусгайлан боловсруулсан асуулгын дагуу бөглүүлэн авч үнэлдэг. Ингэснээр мэдээлэх үүрэгтэй этгээдийн мэдээллийг цуглуулан, дүн шинжилгээ хийж, эрсдэлийг үнэлэх, тэдгээрийн эрсдэлд өртөмтгий байдлын үнэлгээг шинэчлэх, зохицуулалттай салбарын МУТС эрсдэлийн ерөнхий түвшин болоод эрсдэлд суурилсан хяналт шалгалтын цар хүрээг тогтоох ач холбогдолтой.

Санхүүгийн зохицуулах хорооноос МҮЭ-ийн зайны хяналтын үр дүнд үндэслэн эрсдэлд суурилсан газар дээрх хяналт шалгалтыг гүйцэтгэдэг бөгөөд газар дээрх хяналтын хүрээнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (цаашид “МУТСТ” гэх) тогтолцоо, холбогдох хууль, журмын хэрэгжилтийг хангаж буй байдлыг нарийвчлан үнэлж, шалгалтаар илэрсэн алдаа, дутагдлыг залруулах замаар байгууллагын МУТСТ тогтолцоог сайжруулах, МҮЭ-ийн хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх талаар зөвлөмж, заавраар тухай бүр хангаж ажилладаг.

ҮҮРГЭЭ БИЕЛҮҮЛЭЭГҮЙ МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭДЭД ЯМАР АРГА ХЭМЖЭЭ

МҮЭ нь МУТСТ чиглэлээрх зайны хяналтын хүрээнд ирүүлбэл зохих “Эрсдэлийн үнэлгээ”-ний асуулгыг ирүүлэхдээ бүрэн бус, алдаатай, хугацаа хоцроож болон буруу цахим хаягаар ирүүлэх зэрэг нийтлэг алдаа, дутагдлыг гаргадаг. Асуулгыг ирүүлэхэд гардаг нийтлэг алдаа, дутагдал болон асуулгыг огт ирүүлэхгүй байхаас шалтгаалж Санхүүгийн зохицуулах хороо нь тухайн этгээдийг МУТС өндөр эрсдэлтэй байж болзошгүй гэж дүгнэхэд хүргэдэг нь шат дараалсан хариуцлагын болон албадлагын арга хэмжээг авч хэрэгжүүлэх үндэслэл болдог.

Тухайлбал, 2022 оны байдлаар МУТС эрсдэлийн үнэлгээний асуулгыг 1–2 удаа ирүүлээгүй нэр бүхий 427 МҮЭ-д мэдэгдэл, анхааруулгыг хүргүүлсэн бол 3 удаа дараалж ирүүлээгүй нэр бүхий 47 МҮЭ-д улсын байцаагчийн албан шаардлагаар хугацаатай үүрэг, даалгавар хүргүүлж ажилласан. Харин тус асуулгыг 4 удаа дараалж ирүүлээгүй


нэр бүхий 24 МҮЭ-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлээд байна.

МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭД НЬ ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ, ЗААВАР ЗӨВЛӨМЖ

Санхүүгийн зохицуулах хорооноос өөрийн зохицуулалттай МҮЭ-ийн МУТСТ тухай ерөнхий ойлголт, тэдгээрийн чиг үүрэг, мөн тус гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээрх мэдлэг, мэдээллийг сайжруулах, МҮЭ-ийн комплайнсын ажилтнуудыг мэргэшүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах зорилгоор 2021 онд нийт 50, 2022 онд 55 удаагийн сургалтыг салбар тус бүрийн мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулаад байна.

Мөн Санхүүгийн зохицуулах хорооны цахим хуудас дахь “Мөнгө угаахтай тэмцэх” цэсээр дамжуулан, холбогдох хууль, тогтоомж, журам, заавар, түүнчлэн олон улсын болон дотоодын стандарт, гарын авлага зэрэг мэдээллийг тогтмол шинэчлэн хүргүүлдэг бөгөөд эдгээр шаардлагатай мэдээ, мэдээллийг Хорооны цахим хуудаснаас авах боломжтой.

2022 онд МУТСТ тэмцэх чиглэлээр МҮЭ-ийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, тэдгээрт тулгамдаж буй асуудлыг хамтран шийдвэрлэх зорилгоор “Санхүүгийн боловсролын ХАБ” ТББ-тай хамтран “Комплайнсын эрсдэлийг удирдахуй-2022” панел хэлэлцүүлгийг зохион байгуулж, салбарын төлөөлүүдийг хамруулсан нь МҮЭ-ийн хамтын ажиллагаа, мэдээллийн урсгалыг сайжруулах үр дүнтэй арга хэмжээ болсон.



ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ЭРСДЭЛД СУУРИЛСАН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААРХ УУЛЗАЛТАД САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС ИЛТГЭЛ ТАВИЛАА



Санхүүгийн зохицуулах хорооноос Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын Зөвлөмж 15 /Шинэ технологи/-ын үнэлгээг ахиулах хүрээнд өнгөрсөн долоодугаар сард Малайзын Куала Лумпур хотноо болсон Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг /АНДМУТБ/-ийн 25 дахь удаагийн жилийн уулзалтаар Дахин үнэлгээний тайланг Зөвлөмж 15-ын хүрээнд танилцуулж, “хагас хэрэгжсэн” гэж үнэлснийг “дийлэнх нь хэрэгжсэн” болгож ахиулсан билээ. Түүнчлэн АНДМУТБ-ийн урилгаар уулзалтад Санхүүгийн зохицуулах хорооноос Монгол Улс виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн салбарт ФАТФ-ын шаардлага, олон улсын стандартыг нэвтрүүлсэн туршлагаас хуваалцаж, холбогдох илтгэл, тайланг тавьж байсан.

Үүнтэй холбоотойгоор АНДМУТБ-ээс энэ сарын 08-нд “Виртуал хөрөнгө, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчидтэй холбоотой ФАТФ-ын шаардлагын хэрэгжилт: Эрсдэлд суурилсан хяналт шалгалт ба Хууль сахиулах үйл ажиллагаа” сэдвийн хүрээнд цахим уулзалт зохион байгуулж, Монгол Улсаас виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн салбарт эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог хэрхэн нэвтрүүлсэн туршлагаа хуваалцахыг урьсан. Энэ дагуу “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн салбарт эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлж буй Монгол Улсын туршлага, хууль эрх зүйн орчин” сэдвээр илтгэл тавилаа.

Энэ удаагийн уулзалтад АНУ, БНХАУ, Энэтхэг, Малайз, Солонгос, Австрали, Камбож, Сингапур, Мьянмар зэрэг АНДМУТБ-ийн гишүүн орнуудын төлөөлөл оролцсон. Түүнчлэн АНУ-аас виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх туршлагаасаа хуваалцсан бол Австрали болон Сингапур улсын төлөөлөгчид салбарын эрсдэлд суурилсан хяналт шалгалт, зохицуулалтын туршлагын талаар холбогдох илтгэл, тайланг танилцуулсан юм.

ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН КОРПОРАЦИЙН ТӨЛӨӨЛӨГЧИДТЭЙ УУЛЗАВ



Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан Олон улсын санхүүгийн корпорацийн Монгол, Хятад, Солонгос улсыг хариуцсан дарга Рандалл Риопелле, Монгол Улс дахь суурин төлөөлөгч Руфат Алимарданов нартай уулзлаа.

Уулзалтаар хоёр тал хамтран хэрэгжүүлж буй “Ногоон санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх төсөл”, “Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх төсөл”-ийн явц, үр дүнгийн талаар мэдээлэл солилцож, цаашид анхаарах ажлынхаа талаар ярилцсан юм.

Монгол Улсад ногоон санхүүжилтийг хөгжүүлэх бодлого боловсруулах, ногоон төсөл, бизнесийн санхүүжилтийг нэмэгдүүлэх, байгаль орчин, нийгмийн болон засаглалын шаардлагуудыг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй “Ногоон санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд өнөөдрийн байдлаар ногоон бондын зах зээлийг хөгжүүлэх судалгаа хийхийн хамт компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журамд ногоон бондыг бүртгэх зохицуулалтыг тусгасан. Мөн Монгол Улсын Тогтвортой санхүүгийн замын зураглалыг шинэчлэн боловсруулсны зэрэгцээ банк бус санхүүгийн байгууллагуудын байгаль орчин,

нийгэм, засаглалын бодлого, журмын төслүүдийг боловсруулж, Санхүүгийн зохицуулах хороо үлгэрчилсэн журмыг баталсан. Харин цаашид БОНЗ-ын тайлагнал сайн хийдэг компаниудад зориулсан урамшууллын тогтолцоо бий болгох чиглэлд хамтран ажиллах, Монгол Улсын санхүүгийн салбарт уур амьсгалын эрсдэлийн үнэлгээг хийж санхүүгийн байгууллагуудад заавар, чиглэл өгөх, салбарын байгууллагуудын үйл ажиллагаанд БОНЗ эрсдэлийн үнэлгээг нэвтрүүлэхтэй холбоотой сургалт зохион байгуулах чиглэлд хамтран ажиллахаар санал нэгдэв.

Тэгвэл Монгол Улсад өртгийн буюу нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх замаар бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн санхүүжилт авах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй “Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд “Авлага худалдан авалт буюу факторингийн үйл ажиллагаа эрхлэх гарын авлага”-ыг боловсруулаад байна. Мөн “Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн нэр томьёоны тодорхойлолт” номыг Монгол хэл рүү орчуулж, салбарынханд хүргэсний сацуу факторингийн үйлчилгээний гэрээ, стандарт, тавигдах гол шаардлагуудын талаар сургалт зохион байгуулаад байна. Иймд цаашид факторингийн үйл ажиллагааны журмыг батлах, салбарынханд сурталчлах, факторингийн үйл ажиллагааны загвар гэрээг эцэслэн боловсруулах чиглэлд анхаарч ажиллахаар уулзалтаар тогтлоо.

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БҮЙ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮР НӨЛӨӨ БОЛОН ТАТВАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ТАЛААР ХЭЛЭЛЦЛЭЭ



Хөрөнгийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал, цаашид авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээ болон УИХ-аас баталсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийн хүрээнд хөрөнгийн зах зээлийн татварын орчин, шимтгэл хураамж, зах зээлийн мэргэжлийн

байгууллагууд, хөрөнгө оруулагчдад ногдох татварын таатай орчныг бүрдүүлэх, татварын уян хатан бодлогоор Монгол Улсын томоохон ААН-үүдийг урамшуулалтайгаар биржид нээлттэй хувьцаат компани болгон бүртгүүлэх боломжийг нээх зорилгоор “Хөрөнгийн зах зээлд гарч буй бодлого, зохицуулалтын үр нөлөө болон татварын эрх зүйн орчин” сэдэвт хэлэлцүүлэг боллоо.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан хэлэлцүүлгийг нээж “Өнгөрсөн хугацаанд Санхүүгийн зохицуулах хорооноос хөрөнгийн зах зээлийг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, дотоодын аж ахуйн нэгжээс нийтэд санал болгон үнэт цаас гаргах, татах идэвх сонирхлыг өсгөх, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний тоог өсгөх гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлэх чиглэлд онцгой анхаарч ажилласны үр дүнд зах зээлийн үнэлгээ нэмэгдэн бодит эдийн засагт үзүүлэх нөлөө сайжирсан. Гэхдээ хөрөнгийн зах зээлийн санхүү, эдийн засагт үзүүлэх нөлөө азийн бусад орнуудтай харьцуулахад бага байгаа нь олон төрлийн суурь шалтгаантай ба үүнийг шийдвэрлэх нэг арга зам нь татварын уян хатан бодлого юм. Хөрөнгийн зах зээлийн эдийн засагт гүйцэтгэх үүрэг, оролцоог нэмэгдүүлэхийн тулд үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчдад ногдох татварын таатай орчныг бүрдүүлэх замаар дотоодын аж ахуйн нэгжүүдийг олон нийтийн буюу нээлттэй ХК болгож, баялгийн тэгш хуваарилалтыг хөрөнгийн зах зээлийн дамжуулан оновчтой хуваарилан нийгмийн дундаж давхаргыг дэмжих нь чухал ач холбогдолтой. УИХ-аас баталсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийн 4 дүгээр чиглэлд тусгагдсан “Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, өрсөлдөөнийг бий болгож, санхүүжилтийн зардлыг бууруулах” арга хэмжээний хүрээнд хөрөнгийн зах зээлийн татварын орчныг сайжруулах, шимтгэл хураамжийг бууруулах чиглэлээр Сангийн яам, Татварын ерөнхий газартай хамтран олон ажлыг авч хэрэгжүүлээд байгаагийн нэг нь өнөөдрийн хэлэлцүүлэг юм” гэдгийг онцолсон юм.

Хэлэлцүүлгээр мөн хөрөнгийн зах зээлд гарч буй эерэг өөрчлөлтүүдийг хадгалах, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, хөрөнгийн зах зээлийн санхүүгийн салбарт эзлэх байр суурь, мэргэжлийн хөрөнгө оруулагчдын бааз суурийг бэхжүүлэхэд дотоодын хөрөнгийн зах зээлийн татварын эрх зүйн орчинд гарч буй эерэг өөрчлөлт, үнэт цаасны арилжаа, төлбөр тооцооны шимтгэл, хураамжийн хэмжээ буурч буй зэрэг нь ихээхэн ач холбогдолтой хэмээн дүгнэлээ.

Даатгалын компаниудыг мэргэжлийн институциональ хөрөнгө оруулагчид болгох, даатгагчийн хуримтлал, нөөцийн үр ашигт байдлыг нэмэгдүүлэх зорилгоор даатгагчийн хөрөнгө оруулалтын төрөл, хэлбэрийг олон улсын нийтлэг жишгийн дагуу нэмэгдүүлэх, ногоон

бонд, виртуал хөрөнгө, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, хувийн, хамтын хөрөнгө оруулалтын сан, биржээр арилжаалагддаг сан буюу ETF зэрэгт хөрөнгө оруулах боломжийг бүрдүүлсэн зохицуулалтуудыг журамд тусгасан. Дээрх зохицуулалттай холбогдуулан СЗХ-ны Үнэт цаасны газар, Хяналт шалгалт, зохицуулалтын газрын холбогдох албан тушаалтнууд журамд тусгагдсан үнэт цаас болон банк бус санхүүгийн байгууллагын итгэлцлийн үйлчилгээ, тэдгээрийн онцлог, бүртгэлтэй холбоотой мэдээллийг мөн танилцууллаа.

“КОМПЛАЙНСЫН ЭРСДЭЛИЙГ УДИРДАХУЙ -2” ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛЛОО



Эрсдэлд суурилсан аргачлалыг хэрхэн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, ФАТФ-ын зөвлөмж, стандартыг үр дүнтэй биелүүлэхэд тулгамдаж буй зарим асуудлыг шийдвэрлэх арга замыг олох, нэгдсэн ойлголттой болох зорилгоор зохион байгуулж буй “Комплайнсын эрсдэлийг удирдахуй-2” хэлэлцүүлэг өнөөдөр боллоо.

Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал хэлэлцүүлгийг нээж “Одоогоос жилийн өмнө буюу өнгөрсөн оны 12 дугаар сарын 07-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалттай салбаруудын мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулсан “Комплайнсын эрсдэлийг удирдахуй” сэдэвт анхны хэлэлцүүлгийг зохион байгуулж байсан. Тухайн үед Санхүүгийн зохицуулах хороо, “Санхүүгийн боловсролын зангилаа” ТББ комплайнсын соёлыг төлөвшүүлэх чиглэлээр “Хамтран ажиллах санамж бичиг” байгуулсан бөгөөд өнгөрсөн хугацаанд санамж бичиг, хэлэлцүүлгээс гарсан зөвлөмжийн хүрээнд комплайнсын ажилтны ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэшүүлэх сургалтуудыг зохион байгуулсаар ирсэн. Харин өнөөдрийн 2 дахь удаагийн хэлэлцүүлэг нь нэг талаас Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага (ФАТФ)-ын зөвлөмжийн хэрэгжилтийг сайжруулах нөгөө талаас зохицуулалтын салбаруудад комплайнсын эрсдэлийн удирдлагыг нутагшуулах зорилготой.

ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үйл олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх зөвлөмжид урьдчилан сэргийлэх арга хэмжээ чухал байр суурь эзэлдэг. Санхүүгийн зохицуулах хороо ч энэ хүрээнд сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг мэдээллийн бүхий л сувгийг ашиглан зохион байгуулж байна. Тухайлбал, танхимын болон цахим сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, гарын авлага, тараах материал, подкаст, видео хичээл, шторк хийх, цахим хуудас, нийтийн сүлжээгээр цаг үеийн мэдээ, мэдээлэл түгээж байна. Үүний зэрэгцээ комплайнс буюу хууль тогтоомж болон бизнесийн ёс зүй, мэргэжлийн харилцааны хэм хэмжээний стандартын нийцлийг таниулах, мөрдүүлэх, цаашлаад санхүүгийн салбарыг ФАТФ-ын газар дээрх хяналт, шалгалтын үнэлгээнд бэлтгэх зорилгоор компанийн удирдлага, ажилтнуудад комплайнсын гэрчилгээ олгох хөтөлбөрт сургалтыг тун удахгүй зохион байгуулна. Учир нь компанийн удирдлага, ажилтнууд комплайнсын талаар бүрэн мэдээлэл, мэдлэгтэй байх нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, зогсоох зэргээр комплайнсын эрсдэлээ удирдахад чухал юм. Мөн энэ ажлууд хэрэгжсэнээр ФАТФ-аас цаашид хэрэгжүүлэх газар дээрх хяналт, шалгалтын үнэлгээнд бэлтгэх, зохицуулалтын салбаруудад комплайнсын эрсдэлийн удирдлагыг сайжруулах бололцоо бүрдэх учиртай. Хамгийн гол нь үүнийг амжилттай зохион байгуулахад бид бүгдийн санаачилга, идэвхтэй оролцоо, хамтын ажиллагаа тун чухал учраас Та бүхэнтэй үргэлж нээлттэй, хамтарч ажиллана гэдгийг онцольё” гэсэн юм.



Хэлэлцүүлгээр комплайнсын соёлыг түгээх хэрэгцээ, шаардлага, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны талаар баримтлах бодлого, өндөр эрсдэлтэй харилцагчийг таньж мэдэх ажиллагааны талаар мэдээлэл өгөхийн сацуу мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулах хүрээнд салбар бүрийн комплайнсын эрсдэлийг тодорхойлох талаар хэлэлцүүлэг өрнүүлээ.

БАЙР СУУРЬ

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ФИНТЕК ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНД ӨР, ОРЛОГЫН ХАРЬЦАА ТОГТООЛОО

Санхүүгийн зохицуулах хорооны Банк бус санхүүгийн байгууллагын газрын дарга Б.Итгэлсүрэнтэй ярилцлаа.



Санхүүгийн зохицуулах хорооноос ямар үндэслэлээр ББСБ-уудын финтек зээлийн бүтээгдэхүүнд өр, орлогын харьцаа тогтоосон бэ?

Банк эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 19.10-т “Банкнаас олгох зээлийн үйл ажиллагаатай холбогдсон журмыг Монголбанк, эрх бүхий хуулийн этгээдээс олгох зээлийн үйл ажиллагаатай холбогдсон журмыг Санхүүгийн зохицуулах хороо баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина гэж заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 160 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам”-ыг баталсан.

ББСБ-ын салбарт технологид суурилсан зээлийн бүтээгдэхүүн хурдацтай хөгжихийн хэрээр түүнээс үүдэх эрсдэлүүд гарч ирсэн. Тухайлбал, харилцагч нэг зээлийг нөгөө зээлээр хаах замаар өрийн дарамтад орох, харилцагчийн мэдээллийн аюулгүй байдал алдагдах зэрэг эрсдэлүүд үүссэн. Иймээс Санхүүгийн зохицуулах хорооноос эрсдэлийг бууруулах зорилгоор дээрх журмын дөрөвдүгээр бүлэгт финтек зээлийн бүтээгдэхүүнд тавигдах шаардлагыг зохицуулж

өгсөн. Өөрөөр хэлбэл ББСБ-аас финтек зээлийн бүтээгдэхүүн гаргаж буй тохиолдолд Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан өр, орлогын харьцааг хангаж ажиллах зохицуулалтыг тусгасан. Энэхүү зохицуулалтын хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 527 дугаар тогтоолоор банк бус санхүүгийн байгууллагаас олгох финтек зээлийн бүтээгдэхүүнд тооцох өр, орлогын харьцаа 70 хувиас хэтрэхгүй байхаар шийдвэрлэсэн.

Энэхүү харьцааг ББСБ-ууд хэзээнээс эхэлж мөрдөх вэ?

Энэхүү харьцаа нь ББСБ-уудын финтек зээлийн бүтээгдэхүүнтэй холбоотой өр, орлогын харьцаа байгаа тул технологи, программ хангамжийн хөгжүүлэлт хийхэд тодорхой хугацаа шаардагдаж байгааг харгалзан дээрх тогтоолын хэрэгжилтийг 2023 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөн ажиллахаар шийдвэрлэсэн. Мөн ББСБ-ууд нь өр орлогын харьцааг тогтоохдоо Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны А-277 дугаар тушаалаар батлагдсан “Өр, орлогын харьцааг тооцох аргачлал”-ыг мөрдлөг болгон ажиллана.

Финтек зээлийн бүтээгдэхүүнд өр, орлогын харьцаа тогтоосноор ямар үр дүнд хүрнэ гэж үзэж байгаа вэ?

ББСБ-ууд нь финтек зээлийн бүтээгдэхүүн санал болгохдоо тухайн харилцагчийн зээлийн сарын хүүгийн болон үндсэн төлбөр нь сарын татварын дараах орлогын 70 хувиас хэтрэхгүй тохиолдолд зээл олгож болно. Энэ нь нэг талаас санхүүгийн зах зээлд зохицуулалтын орчныг чангаруулах нь тухайн бизнесийн үйл ажиллагаанд хязгаарлалт үүсгэх нөлөөтэй ч нөгөө талдаа өр, орлогын харьцааг 70 хувиар тогтоосноор зээлдэгчид амьжиргааны наад захын хэрэгцээгээ хангах орлогыг нь үлдээх шаардлагыг тавьж байна гэсэн үг. Ингэснээр зээлдэгчийг өрийн дарамтад орохоос урьдчилсан сэргийлсэн томоохон бодлогын шийдвэр юм.


ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

НОГООН ФАКТОРИНГ

Уншигч та сайн байна уу? Энэ удаагийн дугаараар танд ногоон факторингийн талаар хүргэхээр шийдлээ. Факторингийн үйлчилгээ нь компани санхүүгийн байдлын тайлан дээрх дансны авлагаа санхүүгийн байгууллагад барьцаалж зээл аван хөрвөх чадвараа нэмэгдүүлдэг үйлчилгээ юм. Харин ногоон факторинг нь байгаль орчны асуудалд анхаарал хандуулдаг компаниудад факторингийн үйлчилгээг илүү тааламжтай үнээр хүргэдэг байна.

Тухайлбал BBVA компани Нордекс компанийн салхин сэнсний

үйлдвэрлэлийн гурван ногоон факторингийг сертификатжуулсан. Факторинг нь богино хугацааны ажлын капиталыг нөхөхөд бэлтгэн нийлүүлэгчдэд шууд санхүүжилт олгодог. Тиймээс санхүүгийн институт нь салхин сэнсний үйлдвэр үйл ажиллагаагаа явуултал бэлтгэн нийлүүлэгчид төлөх авлагыг барьцаалан төлбөр төлдөг байна. Ингэснээр факторингийн компани нь Тогтвортой хөгжлийн 7 буюу сэргээгдэх эрчим хүч болон 13 буюу уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах зорилтуудад хувь нэмрээ оруулдаг байна.



Эх сурвалж: <https://gazar.gov.mn/p/666-111>



Garanti BBVA хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах хүсэлтэй хэрэглэгчдийг дэмжих Тогтвортой сэдэвт зээлийн хөтөлбөр гаргасан. Хөтөлбөр дэх зээлдэгчид банкны туршлага, бага хүүгийн өртөг, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах чадавх бэхжүүлэх, түншлэх зэрэг үр өгөөжийг хүртдэг.

Invoice компанийн хувьд ногоон факторингийн үйлчилгээ авах жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч нар хүсэлтийг одоогийн уур

амьсгалд нөлөөлж буй байдал болон борлуулах нэхэмжлэхийн хамт хүлээн авдаг.

BBVA компанийн хувьд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад хүртээмжтэй, ногоон факторингийг хөгжүүлэх хүчин зүйлүүдийг хөгжүүлж байна. Үүнд харилцагчдын санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх, дигиталаар үйлчилгээг хүргэхэд ажлуудыг хийдэг байна.

ФИНТЕК БА РЕГТЕК

Р2Р ЗЭЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ

Р2Р зээл гэдэг нь хөрөнгө оруулагч, зээлдэгчдийг ямар нэгэн дундын зуучлагч банк, санхүүгийн байгууллагын оролцоогүйгээр цахим платформуор дамжуулан шууд холбох үйлчилгээ юм. Р2Р зээлийн үйлчилгээ нь хамтын санхүүжилтийн үйл ажиллагааны нэг төрөл бөгөөд уламжлалт бус санхүүгийн үйлчилгээнд (alternative financial services) хамаардаг.

Хүн хүндээ эсхүл бизнес бизнестээ ямар нэгэн дундын зуучлагчгүйгээр шууд зээл олгох бизнес загвар нь шинэ зүйл биш бөгөөд ихэвчлэн гэр бүл, найз нөхөд, бизнесийн хамтрагчид гэх мэт ойр харилцаатай, биенийхээ талаар мэдээлэл сайтай этгээдүүд нэг нэгэндээ санхүүжилт олгох тохиолдол элбэг байдаг. Харин сүүлийн жилүүдэд технологийн дэвшлийн нөлөөгөөр зээлдэгч, хөрөнгө оруулагчдыг шууд холбодог цахим платформын үйл ажиллагаа нэмэгдэн их өгөгдөл, хиймэл оюун ухааны тусламжтайгаар хэрэглэгчдээс зээлийн түүх шаардалгүйгээр хоорондоо хувийн харилцаа холбоогүй зээлдэгч, хөрөнгө оруулагчдыг холбох замаар тус үйлчилгээг үзүүлэх боломжтой болсон.


Р2Р зээл нь хөрөнгө оруулагчийн зээл автоматаар хуваарилагдан зээлийн хүсэлтийг санхүүжүүлэх эсхүл хөрөнгө оруулагч өөрөө

зээлдэгчээ сонгох гэсэн 2 үндсэн төрлөөр хийгддэг бөгөөд Р2Р зээлийн хүүг зээл хүсэгч, хөрөнгө оруулагч талууд хүүгээ санал болгох замаар тогтоох эсхүл талуудыг зуучилж буй байгууллага зээлдэгчийн төлбөрийн чадамжийг үнэлэх замаар тогтоох боломжтой.

Р2Р зээлийн төрлүүд: Р2Р зээлд хөрөнгө оруулагчийн үүрэх эрсдэл нь тухайн Р2Р зээлийн үйлчилгээний бизнес загвараас шалтгаалах ба өнөөгийн байдлаар дараах 4 төрлийн бизнес загвар түгээмэл байна.

1. Стандарт Р2Р зээлийн үйлчилгээ: зээл хүсэгч, хөрөнгө оруулагчдыг шууд холбох үйлчилгээ ба тус үйлчилгээг эрхлэгч нь зээлдэгч болон хөрөнгө оруулагчдыг холбох, хоорондын гүйлгээг хийх, зээлийн үйл ажиллагааг зохион байгуулах үндсэн үүргийг гүйцэтгэдэг. Хөрөнгө оруулагч зээлийн эрсдэлээ өөрөө хүлээх ба зуучлагч платформ нь үндсэн үйл ажиллагаанаас гадна зээлийн чанараас шалтгаалж нэр хүндийн эрсдэл үүрдэг. Энэ төрлийн Р2Р зээлийн загвар нь Англи улсад алдартай бөгөөд зээлийн платформ нь хөрөнгө оруулагч, зээлдэгчийг шууд холбон санхүүжилтийг нь дамжуулдаг.

Зураг. Стандарт Р2Р зээлийн схем




2. Зээлийн үйл ажиллагаа эрхлэгчийн P2P зээлийн үйлчилгээ:

Зээлийн үйлчилгээ эрхэлдэг санхүүгийн байгууллага зуучлалын платформ ашиглан P2P зээлийн үйлчилгээг үзүүлэх. Энд санхүүгийн байгууллага нь зээлийн санхүүжүүлэгчийн үүргийг гүйцэтгэх бөгөөд стандарт P2P зээлийн загвартай харьцуулахад мөнгөн урсгалын хувьд илүү тогтвортой байдаг. Гэхдээ зээлийн

үйл ажиллагаа болон эрсдэлийн удирдлагын талаарх мэдээлэл стандарт загвартай харьцуулахад хэрэглэгчдийн хувьд бага байдаг. Мөн тус загварын P2P зээлийн үйлчилгээнд хөрөнгө оруулагчдыг эрсдэлээс хамгаалах зорилгоор зээлийн баталгаа, даатгал болон бусад төрлийн эрсдэлээс хамгаалах арга хэрэгслийг санхүүгийн компани болон зуучлагч байгууллага санал болгодог.


Зураг. Зээлийн үйл ажиллагаа эрхлэгчийн P2P зээлийн схем



3. Банкны санхүүжилттэй P2P зээлийн үйлчилгээ: Уг загварын хувьд зээлийн санхүүжилтийг банк гаргах бөгөөд зээлдэгч нь банканд зээлийн нөхцөл бүхий амлалтын бичиг/ өрийн бичгийг гарган зээл авч, тухайн банк нь P2P зээлийн платформоор дамжуулан уг амлалтын бичгийг хөрөнгө оруулагчдад худалддаг.

Амлалтын бичгийг зээлийн платформ эзэмшиж буй учраас зээлдэгч эргэн төлөлтөө тус платформд хийнэ. Энэ загварын хувьд банк, зээлийн платформ аль аль нь зээлийн эрсдэлийг үүрэхгүй бөгөөд хөрөнгө оруулагч эрсдэлээ өөрөө хариуцдаг. Энэ төрлийн P2P зээлийн загвар нь АНУ-д түгээмэл байдаг.


Зураг. Банкны санхүүжилттэй P2P зээлийн схем



4. Балансын зээлийн үйлчилгээ: Уламжлалт банк, санхүүгийн үйлчилгээтэй төстэй загвар бөгөөд зуучлагч платформ нь зээлийн үйлчилгээг үзүүлэн түүнийгээ балансын бүртгэлдээ хөрөнгөөр бүртгэн үйл ажиллагаа явуулдаг. Япон улсын хууль, эрх зүй зохицуулалтын системийн онцлогоос шалтгаалан тус улсын P2P

зээлийн загвар нь балансын зээлийн хэлбэртэй ижил, төстэй байдаг. Япон улсад P2P зээлийн үйлчилгээ эрхлэгч нь хөрөнгө оруулалтын гэрээгээр хөрөнгө татан мөнгөн зээлийн гэрээгээр зээлийн үйлчилгээг үзүүлдэг.

Зураг. Балансын P2P зээлийн схем



P2P зээлийн үйлчилгээний давуу, сул тал: Эрсдэл өндөртэй, эсхүл эрсдэлийг тооцоолох нарийвчилсан мэдээллээр дутмаг бага дүнтэй, богино хугацаатай зээл нь өндөр зардал, өгөөж багатай байдаг учраас жижиг дунд, бизнес эрхлэгчид эсхүл өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн хувьд уламжлалт санхүүгийн байгууллага, арилжааны банкнуудын үйлчилгээг авахад хүндрэлтэй нөхцөл үүсдэг.

Сүүлийн жилүүдэд санхүүгийн зах зээлд нэвтэрч буй технологийн дэвшил, түүнд суурилсан шинэ төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээнүүд нь уг асуудлыг шийдэх боломжийг олгож байгаагийн нэг жишээ нь P2P зээлийн үйлчилгээ юм. Зээлдэгч болон хөрөнгө оруулагчдыг ямар нэгэн дундын санхүүгийн зуучлагч байгууллагын оролцоогүйгээр цахим платформыг ашиглан шууд холбох хиймэл оюун ухаан, их өгөгдөл технологийн тусламжтайгаар зээлийн түүх багатай хэрэглэгчийн төлбөрийн чадвар болон зан төлөвийг үнэлэх

замаар зээлийн үйлчилгээг олгож буй нь уламжлалт үйлчилгээтэй харьцуулахад цаг хугацаа хэмнэсэн, зардал багатайгаас гадна санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг олон төрлийн давуу талтай.

Хятад улсад гарч байсан залилангийн гэмт хэргүүд нь зээлд суурилсан хамтын санхүүжилтийн үйлчилгээний томоохон эрсдэлийн нэг жишээ юм. Олон улсад P2P зээл буюу зээлд суурилсан хамтын санхүүжилтийн үйлчилгээний эрсдэлээс шалтгаалсан хяналт зохицуулалтаа хэт чангатгах, улмаар тус салбарын хөгжилд сөрөг нөлөө үзүүлэх эсхүл хэт зөөлөн зохицуулалтын улмаас хэрэглэгчдийг хохироох зэрэг асуудлууд аль аль нь тулгарч буй бөгөөд тус бүтээгдэхүүний зохицуулалт зах зээлийн нөхцөл байдал, цаг үеэ даган хөгжсөөр байна.

Хүснэгт. P2P зээлийн үйлчилгээний давуу ба сул тал

P2P зээлийн үйлчилгээний давуу тал	P2P зээлийн үйлчилгээний сул тал
<ul style="list-style-type: none"> • P2P зээлийн үйлчилгээ нь банкны үйлчилгээг авч чаддаггүй зээлдэгчдэд зээл олгох байдлаар санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлдэг ба платформын зээл олгох процесс нь ил тод байдаг. • P2P зээлийн үйлчилгээ эрхлэгч нь цахим платформыг үйл ажиллагаандаа ашигладаг тул захиргааны болон нэмэлт зардал харьцангуй бага төдийгүй санхүүжүүлэгчид бага зардлаар санхүүжилт авах боломжтой. • Өөрийн бизнесээ олон нийтэд танилцуулах, ирээдүйн хэрэглэгчид, түнш, хамтрагчаа олох боломжтой. • Зээлийн болон хөрөнгө оруулалтын нөхцөлүүд нь нэлээд уян хатан байдаг. Мөн хүүгийн түвшнийг эрсдэлийн түвшинтэй уялдуулах байдлаар тогтоодог. • Хөрөнгө оруулагч, санхүүгийн хэрэгцээнд тохирсон олон хувилбарын санхүүжилтийн боломжуудаас сонголт хийх, эрсдэлээ тараан байршуулах боломжтой. • Бага дүнгээр санхүүжилт хийж өгөөж хүртэх боломжийг олгодог. 	<ul style="list-style-type: none"> • Санхүүжилт хүсэж P2P зээлийн үйлчилгээний платформд байршуулж буй бизнес төсөл патентлагдаагүй бөгөөд зохиогчийн эрх, барааны тэмдэг байхгүй бол бизнес санаа хулгайлагдах эрсдэлтэй. • P2P зээлийн үйлчилгээ нь цахим орчинд явагддаг тул кибер халдлага, мэдээллийн аюулгүй байдал зэрэг бусад холбогдох технологийн эрсдэлд ихээхэн өртдөг. • Хөрөнгө оруулагчийн өндөр өгөөж нь эрсдэлийн түвшинтэй шууд хамааралтай байдаг бөгөөд төлбөрийн чадварын эрсдэл учрах, хөрөнгө оруулагч олгосон зээл хөрөнгө оруулалтын дүнгээ буцааж авч чадахгүй байх эрсдэл үүсэх боломжтой. • P2P санхүүжилт хайж байгаа ихэнх зээлдэгчид зээлийн үнэлгээ багатай төлбөрийн чадамж багатай байдаг. • Мэдээллийн тэгш бус байдлаас шалтгаалан хөрөнгө оруулагч хохирох эрсдэл өндөр байдаг.

P2P зээлийн үйлчилгээний зохицуулалт, олон улсын нөхцөл байдал: Олон улсын хэмжээнд P2P зээлийн зах зээл нь нэлээдгүй өсөлттэй байгаа бөгөөд 2021 оны жилийн эцсээр 83.79 тэрбум ам.доллараар хэмжигдэж байна. “Precedence research” компанийн гаргасан төсөөллөөр тус зах зээл 2030 он гэхэд 705.81 тэрбум ам.доллар хүртэл өснө гэсэн тооцоолол байна. Одоогийн байдлаар Хойд Америкийн P2P зээлийн зах зээл дэлхийд тэргүүлж байгаа бол Ази номхон далайн орнуудын хувьд тус зах зээлийн өсөлт хамгийн өндөр байна. Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахал, санхүүгийн зах зээлд өрнөж буй технологийн хурдацтай хөгжлөөс гадна жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн

өсөн нэмэгдэж буй санхүүжилтийн хэрэгцээ шаардлага зэрэг нь тус зах зээлийн ирээдүйн өсөлтийн таамаглалд нөлөөлж буй гол хүчин зүйлс юм.

Өнөөгийн байдлаар P2P зээлийн үйлчилгээнд хэрэглээний зээл, жижиг дунд бизнес эрхлэгчдийн зээл, сургалтын зээл, үл хөдлөх хөрөнгийн зээл зэрэг зээлийн бүтээгдэхүүнүүд хамгийн түгээмэл байгаа бол АНУ, Канад, Англи, Герман, Франц, Хятад, Энэтхэг, Япон, Өмнөд Солонгос, Малайз, Филиппин зэрэг улсууд P2P зээлийн зах зээлээрээ дэлхийд тэргүүлж байна. Эдгээр улсуудын P2P зээлийн үйл ажиллагаа эрхлэгчийн зохицуулалтыг дараах хүснэгтэд товч харууллаа.

Хүснэгт 2. P2P зээлийн үйлчилгээний зохицуулалт, зах зээлд тэргүүлэгч улсуудаар

Улс	P2P зээлийн үйлчилгээний зохицуулалт
Канад	Канадын үнэт цаасны хороо нь P2P зээлийн зах зээл дээрх зээлийн бүтээгдэхүүнийг үнэт цаасны төрөлд хамааруулан тус үйлчилгээг эрхлэгч P2P зээлийн платформын үйл ажиллагааг үнэт цаасны дилерийн зөвшөөрлийн дор зохицуулдаг.
Англи	Английн санхүүгийн зохицуулагч хороо нь P2P зээлийн үйл ажиллагааг “зээлийн үйлчилгээнд хамаарах цахим систем ажиллуулах үйл ажиллагаа” хэмээн Санхүүгийн үйлчилгээ, зах зээлийг зохицуулах хуульдаа тусган зохицуулдаг.
Герман	Германд P2P зээлийн үйлчилгээг “Германы банкны тухай хууль”-аар зохицуулан банкны тусгай зөвшөөрөл авахыг шаарддаг. Тийм учраас тус улсын P2P зээлийн зах зээлд үйлчилгээ үзүүлэгчид нь ихэвчлэн банк, эсхүл банктэй хамтарсан байдлаар үйл ажиллагаа явуулдаг.
Франц	Франц Улс нь “Санхүүгийн болон мөнгөний зах зээлийн код” эрх зүйн баримт бичигтээ “Зээлд суурилсан хамтын санхүүжилтийн зуучлалын үйл ажиллагаа”, “Хөрөнгө оруулалтад суурилсан хамтын санхүүжилтийн зөвлөхийн үйл ажиллагаа” гэсэн хоёр хуулийн статусыг тусган зохицуулж эхэлсэн.
Энэтхэг	Энэтхэг улсын Төв банк нь санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулдаг зохицуулалтын байгууллагуудаа “Мастер чиглэл” гэсэн эрх зүйн баримт бичгийн хүрээнд зохицуулдаг бөгөөд P2P зээлийн үйлчилгээг тус мастер чиглэлийн “Банк бус санхүүгийн компани” гэсэн бүлэгт “P2P зээлийн үйлчилгээний платформ гэсэн” шинэ хэсгийг оруулан зохицуулж байна.
Хятад	2015 онд Хятадын Төв банк “Интернэт санхүүгийн үйлчилгээний тогтвортой хөгжлийг дэмжих зөвлөмж”-ийг боловсруулсан бөгөөд тус зөвлөмжид P2P зээлийн үйлчилгээг “интернэт зээлийн мэдээллийн зуучлал”-ын үйл ажиллагаа хэмээн ангилж тус бизнес эрхлэгчдийг хадгаламж татахгүйгээр хэрэглэгч, хөрөнгө оруулагч хоорондын санхүүгийн зуучлалыг дангаар үзүүлэх байдлаар тусгасан. Тус үйлчилгээ эрхлэгчдийг “Хятадын банкны зохицуулалтын хороо” хянаж зохицуулдаг.
Япон	Япон улсад P2P зээлийн үйл ажиллагааг мөнгөн зээлийн үйлчилгээ үзүүлэх, хөрөнгө оруулагчдаас хөрөнгө оруулалт татах гэсэн 2 тусад нь хуваан авч үзэж зохицуулдаг. Хөрөнгө оруулалт татах үйл ажиллагааг “Санхүүгийн хэрэгсэл, арилжааны хууль”, зээл олгох үйл ажиллагааг “Мөнгөн зээлийн бизнесийн үйл ажиллагаа эрхлэх хууль”-аар Санхүүгийн зохицуулагч байгууллага нь зохицуулдаг.
Өмнөд Солонгос	Өмнөд Солонгос Улс нь P2P санхүүжилтийн үйл ажиллагаанд зориулан хууль гаргасан анхны улс бөгөөд P2P зээлийн үйлчилгээг тус хуулиар зохицуулан Санхүүгийн үйлчилгээний хороо хяналт, зохицуулалт тавьдаг.
Малайз	Малайз улсад P2P зээлийн үйлчилгээг “Хөрөнгийн зах зээлийн хууль”-аар Үнэт цаасны хороо нь зохицуулдаг. 2016 онд Үнэт цаасны хороо нь P2P зээлийн үйлчилгээнд зориулан “Зохицуулалттай зах зээлд мөрдөх заавар”-ыг боловсруулсан.
Филиппин	P2P зээлийн үйлчилгээг Филиппиний “Үнэт цаасны хороо” хянаж зохицуулдаг бөгөөд хөрөнгө болон зээлд суурилсан хамтын санхүүжилтийн үйлчилгээг аль алиныг нь “Хамтын санхүүжилтийн үйл ажиллагааг зохицуулах журам”-аар зохицуулдаг. Хамтын санхүүжилтийн үйлчилгээг брокер, хөрөнгө оруулалтын компани, санхүүжилтийн портал, цахим платформ ашиглан хамтын санхүүжилтийн компани, хөрөнгө оруулагчид нар эрхэлж болно.

СУДЛААЧИЙН ИНДЭР

ДААТГАЛЫН КОМПАНИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ АРГА ЗАМУУД, ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА /ХУРААНГУЙЛСАН/

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Гүйцэтгэсэн:
Санхүүгийн зохицуулах хорооны Зах зээлийн судалгаа,
хөгжлийн газрын ахлах мэргэжилтэн С.Будбаяр
budbayar@frc.mn



ХУРААНГУЙ

Энэхүү судалгааны ажлаар Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлдэг даатгалын компаниудын дүрмийн сан болон нөөц сангийн байршлыг дэлгэрэнгүй судалж, даатгалын хөрөнгө оруулалтын өнөөгийн байдлыг тодорхойлсон.

Мөн олон улсын даатгалын компаниуд хэрхэн хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлж буйг тодорхойлохоор Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Америкийн Нэгдсэн Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улс болон Монгол Улстай эдийн засаг, газар зүйн байршил болон даатгалын зах зээлийн голлох 2 үзүүлэлт болох даатгалын нягтрал, гүнзгийрэлтийн түвшин ойролцоо Бүгд Найрамдах Казахстан Улс, Арабын Бүгд Найрамдах Египет Улсын туршлагыг судлав.

Судалсан улсуудын даатгалын компанийн хөрөнгө оруулж буй байршлыг судлахад урт хугацааны тогтмол өгөөжтэй, эрсдэл багатай компанийн бонд, засгийн газрын бонд, үнэт цаас зэрэг

нь нийтлэг байв. Улс орнуудын даатгалын компанийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхээр хэрэгжүүлж буй аргачлалын талаар дэлгэрэнгүй судалж, Монгол Улстай харьцуулан дүгнэж, санал дэвшүүллээ.

УДИРТГАЛ

Даатгалын зах зээл нь тухайн улс орны санхүүгийн зах зээлийн чухал бүрэлдэхүүн хэсэг мөн. Даатгалын компанийн үндсэн үйл ажиллагаа нь даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг борлуулж, түүнээс олсон хураамжийн орлогын тодорхой хувиар нөөц сан бүрдүүлэн, нөхөн төлбөр болон зардлыг санхүүжүүлэх юм. Мөн даатгалын компаниуд хөрөнгө болон нөөц сангийн тодорхой хэсгээр хөрөнгө оруулалт хийх замаар хөрөнгийн зах зээлд оролцдог ба нөөц сангийн удирдлагыг амжилттай хэрэгжүүлснээр даатгалын зах зээлийн өсөлтөд эергээр нөлөөлөх боломжтой.

Санхүүгийн зохицуулах хороо нь “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Монгол Улсын Засгийн газрын 2020–2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” зэрэг бодлогын баримт бичигт тусгагдсаны дагуу “Даатгалын тухай хууль”-ийг шинэчлэн найруулахаар үзэл баримтлал болон хуулийн төслийг боловсруулан, УИХ-д өргөн барихаар ажиллаж байна. Дотоодын даатгалын компаниуд шаардлагатай нөөц сангаа хуримтлуулдаггүй, бусад улс орнуудтай харьцуулахад хөрөнгө оруулалтын түвшин бага байгаатай холбогдуулан тэдний үйл ажиллагааг бэхжүүлэх, бодлогын түвшинд дэмжих хэрэгцээ шаардлага үүсэж байна.


Олон улсад даатгалын компаниуд банкны хадгаламжид

байршуулахаас илүүтэйгээр хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулж, өгөөжөө нэмэгдүүлэх сонголтыг илүүтэйгээр хийж байна. Иймд улс орнуудын даатгалын компаниуд хэрхэн хөрөнгө болон нөөц сангаа зөв удирдаж, хөрөнгө оруулалт хийж буй талаар мөн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн тулд зохицуулагч байгууллага болон компани талаас баримталж буй аргачлал, арга замуудын талаар дэлгэрэнгүй судаллаа.

ОЛОН УЛСЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Олон улсад даатгалын компаниуд урт хугацааны тогтмол өгөөжтэй, эрсдэл багатай компанийн бонд, засгийн газрын бонд, үнэт цаас зэрэг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийхээс гадна ногоон бонд, төсөл хөтөлбөр, ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас, хотын бонд болон дериватив буюу үүсмэл санхүүгийн хэрэгсэл зэрэгт хөрөнгөө байршуулдаг байна.

Зураг. Нөөц сангийн байршуулалт




АНУ-ын даатгагчид эрсдэлээс хамгаалах, мөн хөрөнгийн зах зээлд арилжаалагддаг үүсмэл хэрэгслийн даатгалын бүтээгдэхүүнтэй холбоотой эрсдэлийг нөхөх зорилгоор үүсмэл санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулдаг.

Хөрөнгө оруулагч дундаас мэргэжлийн хөрөнгө оруулагчид нь хөрөнгө оруулалтын өөр өөр бодлого баримталдаг хэдий ч ихэвчлэн хөрөнгийнхөө ихэнх хэсгийг бонд, хувьцаанд хөрөнгө оруулдаг. Мэргэжлийн хөрөнгө оруулагчид хөрөнгийнхөө 5–10 хувийг мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө хэлбэрээр хадгалдаг.

Урт хугацааны буюу амьдралын даатгалын компаниудын мэргэжлийн хөрөнгө оруулагчид ихэвчлэн урт хугацаатай санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулдаг бол ердийн даатгалын компаниуд богино хугацаанд, түргэн хөрвөх чадвартай эздийн өмч, харилцах, хадгаламж хэлбэрээр хөрөнгө байршуулдаг байна.


Даатгалын компаниудын дүрмийн сан болон нөөц сангийн хөрөнгө оруулалтын байршлын тайланг шинжлэхэд 2022 оны эхний хагас жилийн байдлаар нийт 168.6 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтад байршуулсан. Үүний 4.8 хувийг мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө хэлбэрээр байгаа бол 95.2 хувийг хөрөнгө оруулалтад байршуулсан байв.

Зураг. Даатгалын компаниудын нийт дүрмийн сан болон нөөц санд эзлэх хувь



Даатгалын компаниудын “Даатгалын компанийн дүрмийн сангийн хөрөнгийн байршил” болон “Даатгалын нөөц санг хөрөнгө оруулалтад байршуулсан тайлан”-гаас нөөц сангийн хөрөнгө оруулалтыг бүрдүүлж буй компани тус бүрээр харахад Үндэсний давхар даатгал 19.3 хувийг, Монгол даатгал 8.7 хувийг, Миг даатгал 8.6 хувийг, Мандал даатгал 7.7 хувийг тус тус эзэлж байна.

Зураг. Нөөц санг хөрөнгө оруулалтад байршуулсан байршил



Зураг. Үнэт цаасны байршуулалт



2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР:

Даатгалын компаниуд дүрмийн сан болон нөөц сангаас 2022 оны эхний хагас жилийн байдлаар нийт 168.6 тэрбум төгрөгийг дараах хөрөнгүүдэд байршуулсан байв.

Үнд 41.7 хувь буюу 70.3 тэрбум төгрөгийг банкны хугацаатай хадгаламжид, 28.6 хувь буюу 48.2 тэрбум төгрөгийг үнэт цаасанд, 9.5 хувь буюу 16.0 тэрбум төгрөгийг үндсэн хөрөнгөд, 8.1 хувь буюу 13.7 тэрбум төгрөгийг бусад санхүүгийн байгууллагад тус тус байршуулсан бол үлдсэн 12.1 хувь буюу 20.4 тэрбум төгрөгийг банкны харилцах, хугацаагүй хадгаламж, хадгаламжийн сертификат, үнэт металл, дериватив болон бусад хөрөнгөд тус тус байршуулсан.

Үнэт цаасанд байршуулсан хөрөнгө оруулалтыг нарийвчлан шинжлэхэд 41.7 хувь буюу 70.3 тэрбум төгрөгийг банкны хугацаатай хадгаламжид, 28.6 хувь буюу 48.2 тэрбум төгрөгийг үнэт цаасанд, 9.5 хувь буюу 16.0 тэрбум төгрөгийг үндсэн хөрөнгөд, 8.1 хувь буюу 13.7 тэрбум төгрөгийг бусад санхүүгийн байгууллагад тус тус байршуулсан бол үлдсэн 12.1 хувь буюу 20.4 тэрбум төгрөгийг банкны харилцах, хугацаагүй хадгаламж, хадгаламжийн сертификат, үнэт металл, дериватив болон бусад хөрөнгөд байршуулсан байна.

УЛСУУДЫН ТУРШЛАГА: Одоогийн даатгалын компаниудын хөрөнгө оруулж буй санхүүгийн хэрэгслийн байршлыг нарийвчлан тодорхойлохоор дэлхийн ердийн болон урт хугацааны даатгалын потенциалын индексийн ТОП 3 улс болох Бүгд Найрамдах Хятад

Ард Улс, Америкийн Нэгдсэн Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын талаар судаллаа. Мөн Монгол Улстай эдийн засаг, газар зүйн байршил болон даатгалын зах зээлийн голлох 2 үзүүлэлт болох даатгалын нягтрал, гүнзгийрэлтийн түвшин ойролцоо Бүгд Найрамдах Казахстан Улс, Арабын Бүгд Найрамдах Египет Улсын талаар судлав.

БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС

Хятадын банк, даатгалын зохицуулах хороо /CBIRC/ нь тус улсын даатгалын компани, зуучлагч, төлөөлөгч, брокер болон хохирол үнэлэгч, тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулж хяналт тавьдаг байгууллага ба даатгалын зах зээлд оролцогчдод тусгай зөвшөөрөл олгодог.

Гадаадын хөрөнгө оруулалттай компани болон гадаад улсад байршилтай компаниудад хөрөнгө оруулалт хийхийг хуулиар хориглодоггүй бөгөөд дараах 2 шаардлагыг тавьдаг:

Хөрөнгө оруулалт хийх гэж буй байгууллагын хөрөнгийн хэмжээ нь сүүлийн санхүүгийн жилд 5 тэрбум ам.доллараас доошгүй байх;

Тухайн байгууллага нь ногоон бүтээгдэхүүнтэй холбоотой үйл ажиллагаа явуулдаг бол хөрөнгийн хэмжээ нь 2 тэрбум ам.доллараас доошгүй байх.

Нөөц сангийн 5.0-аас доош хувьтай тэнцэхүйц хэмжээний хөрөнгө оруулалт хийх гэж буй тохиолдолд зохицуулагч байгууллагад мэдэгдэнэ.

Харин 5.0 ба түүнээс дээш хувиар хөрөнгө оруулах /хувьцаа, бонд, үл хөдлөх хөрөнгө, хадгаламжийн сертификат гэх мэт/ тохиолдолд зохицуулагч байгууллагаас зөвшөөрөл авахаар хуульд заасан байдаг. Хятадын банк, даатгалын зохицуулах хороо нь хөрөнгө оруулалт хийх гэж буй байгууллагыг шалгасны эцэст зөвшөөрөл олгодог байна.

БНХАУ-ын даатгалын компаниуд ихэвчлэн **засгийн газрын бонд, орон нутгийн бонд, санхүүгийн байгууллагаас гаргасан бонд болон хувьцаанд** хөрөнгө оруулалт хийдэг.

АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

АНУ-ын даатгалын зах зээлийг Даатгалын комиссаруудын үндэсний холбоо /NAIC/ зохицуулдаг. Тус улсын даатгалын компаниуд бодит эдийн засагт шууд эерэг нөлөө үзүүлэх урт хугацааны төсөл хөтөлбөр, үйл ажиллагаа, бондыг сонгон шалгаруулж, хөрөнгө оруулдаг. Даатгалын компаниуд урт хугацаатай, хэлбэлзэл багатай, тогтмол өгөөжтэй, эдийн засагт

шууд эерэг нөлөө үзүүлэх хөрөнгө оруулалт хийдэг онцлог стратегитай. Бонд, үнэт цаасанд хөрөнгө оруулах замаар боловсрол, дэд бүтцийн төслүүд, үл хөдлөх хөрөнгө, аж үйлдвэр, барилга байгууламж, тоног төхөөрөмж зэргийг санхүүжүүлдэг.

АНУ-ын даатгалын компаниудын хөрөнгө оруулалтын 4 гол стратеги байдаг ба энэ нь урт хугацаатай, эрсдэл багатай, олон төрлийн байршилд, тохирсон дүнгээр хөрөнгө оруулах юм.

БҮГД НАЙРАМДАХ ЭНЭТХЭГ УЛС

Энэтхэг улсын Даатгалын зохицуулалт, хөгжлийн газар /IRDA/ нь даатгалын компани, брокер, зуучлагч, шинжээч, хохирол үнэлэгч зэрэг оролцогчдыг зохицуулдаг ба хөрөнгө оруулалт хийхдээ зохицуулагч байгууллагаас зөвшөөрөл авахаар дүрэмд заасан байдаг.

Даатгалын дүрэм болох “Гадаадын хөрөнгө оруулалт” болон “2021 оны FI дүрэм”-д зааснаар хөрөнгө оруулах дээд хязгаарыг даатгалын компаниудын хувь нийлүүлсэн хөрөнгийн 74 хувь, даатгалын зуучлагчдын салбарын хувь нийлүүлсэн хөрөнгийн 100 хувь гэж тодорхойлсон байдаг.

Тус улсын хувьд нөөц сангаас бус тусдаа даатгалын хөрөнгө оруулалтын сангаас хөрөнгө оруулдаг онцлогтой.

Энэтхэг улсын даатгалын компанийн хөрөнгө оруулалтын сангаас **бонд, мөнгөний зах зээлийн сан болон эрсдэл багатай үнэт цаасанд** хөрөнгө оруулдаг.

БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛС

Бүгд Найрамдах Казахстан Улсын Санхүүгийн зах зээлийг зохицуулах, хөгжүүлэх агентлаг нь даатгалын зах зээл болоод нийт санхүүгийн зах зээлийн зохицуулагч байгууллага. Тус агентлаг нь санхүүгийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн зах зээлийн хөгжлийг дэмжих, зах зээлийн оролцогчдыг хянах, зохицуулах чиг үүрэг бүхий төрийн байгууллага юм.

Зохицуулагч байгууллагын зүгээс дараах нөхцөлд дэмжлэг үзүүлдэг байна. Үүнд:

1. Үйлдвэрлэлийн салбарыг дэмжих;
2. Бусад салбарт шууд эергээр нөлөөлөх урт хугацаатай хөрөнгө оруулалт;
3. Инновацийн салбар дахь хөрөнгө оруулалт.

Өндөр хөгжилтэй орнуудын даатгалын салбарын хөрөнгийг ДНБ-тэй харьцуулахад 8.0–14.0 орчим хувь байхад 2.0 хувиар Казахстан улсынх 2.0 хувиас хэтрэхгүй байгаа нь даатгалын зах зээлийн хөгжил удаашралтай, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл бага байдгийг харуулж байна. Мөн нөөц сангийн байршуулалт, хөрөнгө оруулалт хийх боломж, дагаж мөрдөх журам зохицуулалт, хөрөнгө оруулалт хийх дээд хэмжээ, стандартыг боловсруулаагүй байгаа нь Казахстан улсын хувьд хөрөнгө оруулалт хийх хууль эрхзүйн орчныг бүрдүүлж өгөөгүй байна.

Казахстан улсын даатгалын компаниуд ихэвчлэн **хувьцаа, Засгийн газрын үнэт цаас, хугацаатай хадгаламжид** хөрөнгө оруулалт хийдэг байна.

АРАБЫН БҮГД НАЙРАМДАХ ЕГИПЕТ УЛС

Өмнө нь тус улсын даатгалын салбарыг Египетийн даатгалын хяналтын газар зохицуулдаг байсан бол одоо Санхүүгийн зохицуулах газар /FRA/ хянаж, зохицуулдаг.

Египет улсад даатгалын болон давхар даатгалын үйл ажиллагаа явагдан 100 гаруй жил болсон хэдий ч хөрөнгийн зах зээл, даатгалын зах зээлийг холбосон санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ хараахан хөгжөөгүй байна.

Египетийн даатгалын хяналтын газрын стратеги төлөвлөгөө (2020–2024 он)–нд даатгалын компаниудын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх тухай шалгуур үзүүлэлт тусгаснаар компанийн бонд, Засгийн газрын үнэт цаас, банкны хугацаатай хадгаламж зэрэгт хөрөнгө байршуулж байна. Мөн тус улсын Сангийн сайд, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Мохамед Мааит нь “Хөрөнгө оруулалтын багцыг төрөлжүүлэх, өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудад хөрөнгө оруулах зорилготой байгаа” хэмээн хэлжээ.

Египет улсын даатгалын компаниуд бонд, Засгийн газрын үнэт цаас болон банкны хадгаламжид хөрөнгө оруулдаг:

ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ АРГА ЗАМ: Улс орнуудын даатгалын компанийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж буй аргачлалыг нарийвчлан судлахад дараах 8 арга замыг нийтлэг хэрэгжүүлж байв.

Хөрөнгө оруулалт хийх эрх зүйн орчныг бүрдүүлэх;

Даатгалын компанийн нөөц санг зарцуулах, хөрөнгө оруулалтад байршуулахтай холбоотой хууль, тогтоомж, стандартыг, ерөнхий чиглэлийг боловсруулж, хөрөнгө оруулалт хийх нөхцөлийг бүрдүүлдэг.

Хөрөнгө оруулалтад тавигдах шаардлагыг өөрчилж, уян хатан зохицуулалт бий болгох;

Улс орнуудын даатгалын зах зээлийн зохицуулагч байгууллага болон тухайн улсын Засгийн газраас даатгалын компанийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн тулд журам, бодлогод өөрчлөлт оруулж, уян хатан зохицуулалтыг бий болгож байна. Ингэснээр даатгалын компанийн хөрөнгө оруулалт нэмэгдэх боломж үүссэн.

БНХАУ-ын даатгалын зах зээлийн зохицуулагч байгууллага болох Хятадын банк, даатгалын зохицуулах хорооноос 2022 оны 02 дугаар сард гаргасан шинэ журамд даатгалын компаниуд үл хөдлөх хөрөнгө, орон сууцны төслүүдэд урт хугацааны хөрөнгө оруулалт хийх хөнгөлөлттэй нөхцөлийг бүрдүүлж өгсөн. Хятадын 14–р таван жилийн төлөвлөгөөний (2021–2025) нэг хэсэг бөгөөд хямд түрээсийн орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилготой юм. Ингэснээр үл хөдлөх хөрөнгө, орон сууцны төслүүдийг санхүүжүүлэх хөрөнгө оруулалт нэмэгдэж, хөрөнгө оруулалтын орлого нэмэгдсэнээр даатгалын компаниуд эергээр нөлөөлнө гэсэн хүлээлттэй байна.

БНХАУ-ын даатгалын компаниуд өмнө нь зөвхөн орон нутгийн зээлжих зэрэглэл “А” ба түүнээс дээш үнэлгээтэй бондод хөрөнгө оруулах боломжтой байсан бол зохицуулагч байгууллагаас тус шаардлагыг бууруулж одоо “BBB” ба түүнээс дээш үнэлгээтэй санхүүгийн бус байгууллагын гаргасан бондод хөрөнгө оруулах боломжийг бий болгосон.

АНУ-ын даатгалын компаниуд нь Даатгалын комиссаруудын үндэсний холбооноос боловсруулсан хөрөнгө оруулалтын стратегийг дагаж мөрддөг ба тус стратегид даатгалын компаниуд нь улс орны эдийн засагт шууд нөлөөлөхүйц салбарыг санхүүжүүлэх тухай тусгасан байдаг. Засгийн газрын бонд, компанийн бонд, ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас зэрэгт хөрөнгө оруулах замаар боловсрол, дэд бүтэц, барилга байгууламж, үл хөдлөх хөрөнгө, аж үйлдвэрийг дэмжин ажилладаг төсөл хөтөлбөрийг санхүүжүүлдэг.

Зохицуулалтын байгууллагууд тухайн орны нөхцөл байдал, онцлогт тохирсон нөөц сангийн бодлогыг тодорхойлох;

Улс орнуудын зохицуулагч байгууллагууд нөөц санг хөрөнгө оруулалтад байршуулах хувь, хөрөнгийн ангилал, тусгай шаардлага зэргийг нарийн тодорхойлсон нөөц сангийн бодлогыг боловсруулан ажиллаж байна.

Даатгалын компаниуд тус бодлого, журмын дагуу үйл ажиллагаа явуулж байгаа нь хөрөнгө оруулалтын өсөлтөд шууд нөлөөлж байна. /Монгол – нөөц санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ, түүнийг хөрөнгө оруулалтад байршуулахад тавигдах шаардлагыг тодорхойлсон байдаг /

Хөрөнгө оруулалтыг оновчтой болгох хөшүүргийг бий болгох, хэрэгжүүлэх;

Хөрөнгө оруулалтад нөлөөлөх хүчин зүйлүүдийг нарийвчлан тодорхойлж, хөшүүргийг бий болгож хэрэгжүүлэх нь даатгалын компанийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой.

Чадавхтай хүний нөөцтэй байх шаардлага тавих;

Даатгалын компаниуд ажилчдаа хөрөнгө оруулалтын чиглэлээр сургалтад хамруулах, зохих түвшний мэдлэгээр хангах, мэргэшүүлэх зэрэг нь хөрөнгө оруулалтад чухал нөлөөтэй байдаг тул хөрөнгө оруулалт хийж байсан туршлагатай, өгөөж, эрсдэлийн тооцоолол хийдэг гэх мэт чадвартай боловсон хүчинтэй байхыг зохицуулагч байгууллагын зүгээс шаардах нь оновчтой. (АНУ–ын даатгалын компаниуд хөрөнгө оруулалтын туршлагатай ажилчидтай байдаг ба тогтмол сургалт зохион байгуулж чадавхжуулдаг)

Өндөр өгөөжтэй хөрөнгө оруулалтын багц сонгох;

Улс орнууд даатгалын компаниуд хөрөнгө оруулалт хийхээсээ өмнө олон төрлийн хөрөнгө оруулалтын багцыг бүрдүүлэн, харьцуулалт хийдэг. Тэр дундаас өөрсдийн үйл ажиллагаанд

тохирсон, өндөр өгөөжтэй хөрөнгө оруулалтын багцыг сонгосноор орлогоо нэмэгдүүлэх боломжтой.

Эрсдэл багатай, өндөр өгөөжтэй хөрөнгө оруулалт хийх;

Санхүүгийн хэрэгслүүд болон хөрөнгө оруулалтын хэлбэрийг судалж, эрсдэл өгөөжийн шинжилгээ хийсний үндсэн дээр тухайн компанид тохирсон хөрөнгө оруулалтыг хийх нь зохистой. Ингэснээр хэт эрсдэлтэй хөрөнгө оруулалт хийж алдагдалд орох эрсдэлээс сэргийлнэ. /БНХАУ, АНУ нь эрсдэл багатай, тогтмол өгөөжтэй Засгийн газрын бондод хөрөнгө оруулдаг/

Хөрөнгө оруулах гэж буй байгууллага, санхүүгийн хэрэгслийг судлах.

Хөрөнгө оруулах гэж буй бонд, хувьцаа гэх мэт санхүүгийн хэрэгслийг зах зээлд гаргасан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн баримталж буй бодлого, хөрөнгө оруулалт хэрхэн татаж буй талаарх мэдээллийг судлах шаардлагатай. Дараах хүчин зүйлсээс хамаарсан хөрөнгө оруулалтын стратегийг тодорхойлох аргачлалыг аудитын Deloitte компани боловсруулсан байдаг:

Хөрөнгө оруулалтын багц

Аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө оруулалтын бодлого

Аж ахуйн нэгжүүдийн татварын тогтолцоо

Эдийн засгийн эрсдэл

Хөрөнгө оруулалтын өгөөж



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО нь дараах чиг үүрэг бүхий Төрийн байгууллага:

- санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах;
- санхүүгийн үйлчилгээг зохицуулах;
- холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих;
- хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО нь дараах зах зээл, салбарт хяналт, зохицуулалт тавин ажиллаж байна.



**ХӨРӨНГИЙН
ЗАХ ЗЭЭЛ**



**ДААТГАЛЫН
ЗАХ ЗЭЭЛ**



**БАНК БУС САНХҮҮГИЙН
БАЙГУУЛЛАГУУД**



**ХАДГАЛАМЖ,
ЗЭЭЛИЙН ХОРШОО**



**ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ,
ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН
ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧ**



**ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ
ЗУУЧЛАЛЫН
БАЙГУУЛЛАГУУД**



**ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН
ҮЙЛЧИЛГЭЭ
ҮЗҮҮЛЭГЧ**



**СЭНДБОКС
ЗОХИЦУУЛАЛТЫН
ОРЧИН**



**МӨНГӨН ЗЭЭЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭГЧ /2023 он/**

Үйл ажиллагааны ЗАРЧИМ:



БИЕ ДААСАН



ИЛ ТОД БАЙХ



**БУСДЫН НӨЛӨӨНД ҮЛ
АВТАХ**



**САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН
ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ**



**НИЙТИЙН ЭРХ, ХУУЛЬ ЁСНЫ
АШИГ СОНИРХЛЫГ ХАМГААЛАХ**

БҮРЭН ЭРХ:

Хэрэгжүүлтэд хяналт тавих:



Санхүүгийн үйлчилгээтэй холбоотой **ХУУЛЬ ТОГТООМЖ;**



Санхүүгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, зөвшөөрлийн **НӨХЦӨЛ, ШААРДЛАГЫГ БИЕЛҮҮЛЖ БАЙГАА ЭСЭХ;**



Бүрэн эрхийнхээ хүрээнд **ДҮРЭМ, ЖУРАМ, ЗААВАР БАТАЛЖ.**

Зөвшөөрөл эзэмшигч, бүртгэлтэй этгээдийн ҮЙЛ АЖИЛЛАГААГ ШАЛГАХ;



Санхүүгийн зах зээлийн ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ДЭМЖИХ зорилгоор шаардлагатай ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, БУСАД ХЭМ ХЭМЖЭЭ ТОГТООХ;





Зөвшөөрөл эзэмшигч хооронд болон зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгч хооронд гарсан МАРГААНЫГ эрх хэмжээнийхээ хүрээнд ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ.


СЭНДБОКС ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН:

- Технологид суурилсан шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загвар
- Зохицуулагч байгууллагын хяналт, зохицуулалт дор
- хязгаарлагдмал хүрээ, бодит орчинд, тодорхой цаг хугацаанд турших.

СЭНДБОКСЫН ОРОЛЦОГЧДОД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- ✓ Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд байх;
- ✓ Банк, санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх;
- ✓ Хувьцаа эзэмшигчид, удирдах түвшний албан тушаалтнууд нь өмнө нь мөнгө угаах болон эдийн засгийн гэмт хэрэгт ял шийтгэлгүй байх;
- ✓ Хувьцаа эзэмшигчийн оруулж буй хувь хөрөнгө нь Мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан шаардлагыг хангасан байх;






КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН (ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ) 2022 ОНЫ “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 2 дугаар зүйлийн 2.1.5–д заасны дагуу тус Хороо нь санхүүгийн зах зээлд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн засаглалын зарчмыг нэвтрүүлэх, боловсронгуй болгох үндсэн зорилтыг хангах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. Энэ хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо 2022 оны 3 дугаар сарын 23–ны өдрийн 145 дугаар тогтоолын хавсралтаар “Компанийн засаглалын кодекс”-ийг шинэчлэн баталсан. Шинэ кодексоор нээлттэй хувьцаат компаниас гадна даатгагч, итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч ББСБ болон хөрөнгө оруулалтын менежментийн компанийг үйл ажиллагаандаа мөрдөхийг үүрэг болгосон.

Кодексийн хэрэгжилтийг аргачлалын дагуу үнэлэн “Итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч банк бус санхүүгийн байгууллагуудын 2022 оны компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээний тайлан”-г танилцуулж байна.

Зураг. Кодексийн хэрэгжилтийн тайлангийн ахиц дэвшлийн үзүүлэлт



Итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч 62 ББСБ–ын кодексийн хэрэгжилтийг үнэлэхэд 2022 оны 8 дугаар сард 53.5 хувийн гүйцэтгэлтэй байсан бол заавар зөвлөмж, чиглэл, хугацаатай үүрэг даалгавар өгсний дараах үнэлгээ 2022 оны 10 дугаар сард 76.6 хувь буюу өмнөх үнэлгээнээсээ 23.1 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.

Зураг. ТУЗ-ийн бүтэц



Зураг. ТУЗ-ийн бүрэлдэхүүн



ТУЗ нь 5–9 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Үүнээс 1–3 нь хараат бус, 4–6 нь энгийн гишүүн байна.

Зураг. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга



Зураг. ТУЗ-ийн үйл ажиллагаа



2022 онд хийсэн ТУЗ-ийн хурал дунджаар 8 удаа, хурлын дундаж ирц 98 хувьтай, хурлаар хэлэлцсэн асуудлын дундаж тоо 3-тай байна.

ТУЗ-ийн бүрэлдэхүүний 78 хувийг эрх зүйч, эдийн засагч, санхүүч, бизнесийн удирдлагын чиглэлээр мэргэшсэн гишүүд бүрдүүлж байна.

ТУЗ-ийн дэргэдэх хороод:


Дунджаар 72 хувь нь ТУЗ-ийн дэргэдэх Аудитын, Нэр дэвшүүлэх болон Цалин урамшууллын хорооны чиг үүргийг давхардуулан хэрэгжүүлж байна.

ТУЗ-ийн дэргэдэх хороод тус бүр 1-3 гишүүнтэй.

Хамгийн сул хэрэгжсэн компанийн засаглалын үзүүлэлтүүд:



Зураг. ТУЗ-ийн бүрэлдэхүүний мэргэшил байдал



САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ

СТАТИСТИКИЙН ТООЦООЛЛЫН СУУРЬ ОЙЛГОЛТУУД ХИЧЭЭЛ №10



ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ
ГАЗРЫН ДАРГА В.ЭНХБААТАР

ХУВЬЦААНЫ ҮНЭЭР ЖИГНЭСЭН ИНДЕКС

Хувьцааны үнээр жигнэсэн индекс нь багцад байх хөрөнгө, үнэт цааснуудыг эдгээрийн нэгж үнээр нь нийт багцад эзлэх жинг тооцоолсон индекс юм. Индексийн үнэ цэнийг тооцоход багцад багтсан өндөр үнэ бүхий үнэт цаас нь бага үнэтэйгээс илүү нөлөө үзүүлнэ, иймд өндөр үнэтэй хувьцаа, үнэт цаасны үнийн хөдөлгөөн индексийн үнийг тодорхойлоход гол нөлөөлнө.

Хувьцааны үнээр жигнэсэн индекст өндөр үнэ бүхий үнэт цаасны үнийн багахан хөдөлгөөн индексийн үнэд ихээр нөлөөлдөг тул хөрөнгийн удирдлагын компаниуд шүүмжлэлтэй ханддаг. Энэ индексийн тухайн багцад байх үнэт цаасны жинг багцын бүх үнэт цаасны үнийн нийлбэрт харьцуулна, үүнийг дараах байдлаар томъёолно:

$$\text{Жин} = \frac{P_i}{P_1 + P_2 + \dots + P_n}$$

(P – хувьцааны үнэ, i – хувьцаа, хөрөнгийн тухайлсан дугаар)

Үнээр жигнэсэн индекс	
Хувьцаа/үнэт цаас	Үнэ ₮
Компани А	5
Компани В	10
Компани С	20
Компани D	15

$$\text{Жин}_A = \frac{5}{5 + 10 + 20 + 15} \times 100\% = 10\%$$

Үнээр жигнэсэн индексийн үнийг багцын үнэт цааснуудын үнийн нийлбэрийг хуваагчид хувааж тооцоолно. Дээрх жишээний хувьд хуваагчийг бодъё, индексийн үнийг 100-аас эхэлнэ гэж стандартчилбал хувьцааны үнийн нийлбэрийг 100-д хувааж 'хуваагчийг' олно.

$$\text{Хуваагч} = \frac{5 + 10 + 20 + 15}{100} = 0.5$$

Энэ хуваагчийг ашиглан тодорхой хугацааны дараа индексийн үнэт цааснуудын өөрчлөлтийг үндэслэн индексийн үнийг тооцоолно. Жишээлбэл, 7 хоногийн дараа индексийн үнэт цааснуудын үнэ хөдөлж, нийлбэр 56 болсон гэж төсөөлье, тэгвэл индексийн үнэ индексийг тооцож эхэлсэн үнэ 100-аас 12 нэгжээр өссөн үзүүлэлттэй байна, ийнхүү индексийг цааш цаг хугацааны хувьд тодорхой давтамжаар тооцоолно.

$$\text{Индекс үнэ} = \frac{56}{0.5} = 112$$

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

2023 ОНЫ ДЭЛХИЙН ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨСӨЛТИЙН ТААМАГЛАЛАА БУУРУУЛАВ.



“Fitch Ratings” агентлаг нь 2022 оны 9 дугаар сарын байдлаар ирэх оны ДНБ-ийг 1.7 хувиар өснө гэж таамаглаж байсан ч 12 дугаар сарын 05-ны өдөр таамаглалаа 0.3 пунктээр бууруулж, ДНБ-ийг 1.4 хувиар өснө гэсэн таамаглалыг дэвшүүлжээ. Үүнд төв банкуудын инфляцын эсрэг тэмцэл болон БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн төлөв байдал муудсан нь голлон нөлөөлсөн байна.

Мөн мөнгөний бодлого эрчимтэй чангарч байгаатай холбогдуулан АНУ-ын эдийн засгийн өсөлтийн таамаглалыг 0.5 хувиас 0.2 хувь болгон бууруулсан бол БНХАУ-ын ДНБ-ий өсөлтийн таамаглалыг 4.5 хувиас 4.1 хувь болгон бууруулсан нь орон сууцны барилгын ажил сэргэх хэтийн төлөв сул байгаатай холбоотой.

Европын хийн хямрал бага зэрэг намжсан байгаа учир Fitch агентлаг 2023 оны Евро бүсийг ДНБ-ий өсөлтийг -0.1 хувь байсныг 0.2 хувь болгон нэмэгдүүлсэн байна.

www.fitchratings.com

ОХУ-ЫН ГАЗРЫН ТОСНЫ ЭКСПОРТОД ТАВЬСАН ХОРИГ БОЛОН ҮНИЙН ДЭЭД ХЯЗГААР ХЭРЭГЖИЖ ЭХЭЛЛЭЭ.



ОХУ-ын газрын тосны экспортод тавьсан барууны хориг 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрөөс албан ёсоор хэрэгжиж эхэллээ. Тодруулбал, Европын Холбоо ОХУ-аас далайгаар экспортод газрын тос авахаа зогсоож байгаа бол далайгаар тээвэрлэдэг ОХУ-ын газрын тосны үнийг нэг торх тутамд 60 ам.доллараар хязгаарлах хязгаарлалтыг “Их долоо”-ийн орнууд хэрэгжүүлж эхэллээ.

ОХУ нь Европт газрын тос нийлүүлэгч гол орон байсан ба нийт Европын газрын тосны хэрэгцээний 20 орчим хувийг дангаар хангадаг байжээ. Гэвч ОХУ Украины мөргөлдөөний улмаас тус хориг арга хэмжээг авч эхэлсэн бөгөөд энэ нь газрын тосны экспортоос олох томоохон орлогын эх үүсвэрийг хязгаарлах зорилготой юм.

Эх сурвалж: www.nytimes.com

ТӨВ АЗИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЧУУЛГА УУЛЗАЛТ ТОКИОД ЭХЭЛЖЭЭ.



2022 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Япон улсын нийслэл Токио хотод бүс нутгийн эрх баригчид, бизнес эрхлэгчдийн төлөөлөл оролцсон Төв Азийн хөрөнгө оруулалтын чуулга уулзалт зохион байгуулагдав.

“Тогтвортой өсөлтийн гүүрийг бий болгоё” уриатай зохион байгуулагдсан тус арга хэмжээг Европын сэргээн босголт, хөгжлийн банк, Японы Засгийн газар, Японы Олон улсын хамтын ажиллагааны банк (JBIC) болон Японы олон улсын хамтын ажиллагааны агентлаг (JICA) нар зохион байгуулсан байна.

Тус арга хэмжээнд Төв Азийн худалдаа, хөрөнгө оруулалттай холбоотой хэд хэдэн асуудлыг хэлэлцэхээр байна. Мөн бүс нутгийн эрчим хүчний салбарын өөрчлөлт, ногоон эрчим хүч, дэвшилтэт дэд бүтцийг хөгжүүлэх гэх мэт хэд хэдэн асуудлыг хэлэлцэхээр хуралдаан зохион байгуулна.


Эх сурвалж: www.bigasia.ru

ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2022 оны 12 дугаар сарын 12-ны өдөр


S&P 500 /^GSPC/

3,934.38 -29.13 (-0.73%)




Nikkei 225 /^N225/

27,842.33 -58.68 (-0.21%)




FTSE 100 /^FTSE/

7,457.92 -19.52 (-0.26%)



NASDAQ Composite (^IXIC)

11,004.62 -77.38 (-0.70%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

© САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC_of_Mongolia

